

## **ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН 2020 ОНЫ 6 ДУГААР САРЫН ЦАГ ҮЕИЙН МЭДЭЭ**

### **НЭГ. УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ХҮРЭЭНД**

Аймгийн Удирдах ажилтны шуурхай зөвлөгөөнийг 2 удаа зохион байгуулж, сумд болон Засаг даргын харьяа хэлтэс, агентлагийн дарга нарт 4 үүрэг даалгавар өгч, хэрэгжилтийг хангуулан ажилласан.

Тайлант хугацаанд аймгийн Засаг даргын Тамгын газрын нийгмийн сүлжээний хуудсанд нийт 32 удаагийн мэдээллийг нийтэлсэн. Үүнд: Газрын төлбөр, хураамжийн өөрчлөлтийн тухай шууд видео бичлэг болон аймгийн бүтээн байгуулалт, хөрөнгө оруулалтын тухай 8 дүрс бичлэгийг нийгмийн сүлжээгээр цацсан бөгөөд давхардсан тоогоор нийт 107000 иргэнд хүргэсэн.

Засгийн газрын 2019 оны дөрөвдүгээр сарын 17-ны өдрийн 149 дугаар тогтоолын дагуу Улаанбаатар хот болон орон нутагт үйл ажиллагаа явуулж байгаа “Нэг цонхны үйлчилгээ”, “Төрийн үйлчилгээний нэгдсэн төв”-ийг операторын хэлбэрээр үйлчилгээ үзүүлдэг “Үйлчилгээний нэгдсэн төв” болгон өөрчилж зохион байгуулах, бүх сумдад “Үйлчилгээний нэгдсэн төв” байгуулж иргэн, хуулийн этгээдэд төрийн зарим үйлчилгээг цахим хэлбэрээр үзүүлэх, төрийн мэдээлэл солилцооны “ХУР”, “ДАН” системийг нэвтрүүлэх ажлын хүрээнд улсын төсвийн 5.0 сая төгрөгийн техник, тоног төхөөрөмжийг сум тус бүрт хүлээлгэн өгсөн.

2020 оны 6 дугаар сарын 21-ний өдөр түр зуурын хүчтэй аадар бороо орсоны улмаас Баянтал, Сүмбэр сумын нутаг дэвсгэрт үер бууж, үер, усны аюулын хохирлыг тогтоох, нөхөн сэргээх, хохирлыг бууруулах арга хэмжээг хэрэгжүүлэн ажиллалаа. Тус ажлын хүрээнд Улаанбаатар Төмөр зам ХХН-ээс төмөр замын 8 хэсэгт эвдрэл үүссэнийг засварлах, аймгийн Онцгой комисс, Засаг даргын Тамгын газраас үерт өртсөн айл өрхийн байдалтай газар дээр нь танилцаж, үнэлгээ хийн, мал, амьтны сэг зэмийг устгаж цэвэрлэх, халваргүйтгэл, ариутгалыг хийх, үерт өртсөн өрхүүдэд гэр болон эд материалын тусламж, дэмжлэг үзүүлэх арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлээ. Одоогоор үерийн хохирлыг барагдуулах ажлын хүрээнд 3 өрхөд гэр олгон, 7 өрхөд хүнсний болон эд материалын дэмжлэг үзүүлж, 2065 толгой малын сэг, зэмийг цэвэрлэж, ариутгал, халдваргүйтгэлийг хийгээд байна. Тус арга хэмжээнд аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс 3289780 , аймгийн Орон нутгийн хөгжлийн сангийн Гамшгаас хамгаалах арга хэмжээний зарлаас 2454400 төгрөгийг тус тус зарцуулсан.

Монгол Улсын Шадар Сайдын баталсан “Маскаа зүүцгээе” аяны хүрээнд Онцгой байдлын газар, Цагдаагийн хэлтэс хамтран “Ковид–19” халдвараас сэргийлж амны хаалтаа зүүж, эрүүл ахуйн зөв дадал, хэвшлийг төлөвшүүлэх, иргэдийн хариуцлагыг нэмэгдүүлэх сурталчилгааны ажлыг 2020 оны 06 дугаар сарын 11-ний өдөр 18:00-20:00 цаг хүртэл тусгай зориулалтын автомашины чанга яригч, зөөврийн чанга яригчаар 18 км явж 10 газарт 6-10 удаагийн давтамжтай, нийт 160 удаа нэвтрүүлэн давхардсан тоогоор 12000 иргэнд хүргэн, томоохон худалдааны төв, гудамжаар амны хаалтгүй явж буй иргэдэд 250 ширхэг амны хаалт тараан, тоглоомын талбайд хүүхэд олноор тоглохгүй байх, амны хаалтаа зүүж хэвших, амны хаалтаа зүүгээгүй иргэдийг зөрчлийн тухай хуулийн 5.13.1-д зааснаар торгох арга хэмжээг авах талаар яриа танилцуулга хийж, 2 нэр төрлийн 100 ширхэг гарын авлага тарааж зохион байгуулсан.

### **ХОЁР. ЭДИЙН ЗАСАГ, ТӨСӨВ, САНХҮҮГИЙН БОДЛОГЫН ХҮРЭЭНД**

2020 оны 6 дугаар сарын Орон нутгийн татварын орлогын төлөвлөгөө 2437986.7 мян.төгрөг төвлөрүүлэхээс, 22480740.0 мян.төг төвлөрүүлж, төлөвлөгөөг 1.7 хувиар давуулан биелүүлсэн.

2020 оны 6 дуаар сарын 24-ний өдрийн байдлаар татвар төлөгч ХК-1, ХХК-303, ББН-5, ЗБН-10, Хоршоо-27 ОНӨҮГ-6, Салбар-70, Хадгаламж зээлийн хоршоо-1, Төсөвт

байгууллага-57, ТББ-92, Шашны байгууллага-5, Сан-10, ОНБ-16 бүртгэгдэн нийт хуулийн этгээд 603 болж 4.5 хувиар нэмэгдсэн байна.

Орон нутгийн төсвийн байгууллагуудад 4575516.2 мянган төгрөг, Тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудад 5339290.4 мянган төгрөг, ОНХСанд 238960.0 мянган төгрөгийн зарцуулалтын эрх төсвийн хуваарийн дагуу бүрэн нээгдэж төрийн сангийн гүйлгээ хэвийн явагдаж байна.

**Статистикийн чиглэлээр:** 2020 оны 5 дугаар сарын нийгэм, эдийн засгийн танилцуулга гаргаж байгууллагын цахим хуудсанд байршуулж, хэвлэмэл байдлаар 47, цахимаар 155 иргэнд хүргэсэн.

**Санхүүгийн хяналт, аудитын чиглэлээр:** Аймгийн нэгдсэн эмнэлгийн 2019 оны санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж 5546.3 мянган төгрөгийн зөрчил илрүүлж, 992.7 мянган төгрөгийг холбогдох эздээр нөхөн төлүүлж, орон нутгийн орлогод төвлөрүүлэхээр улсын ахлах байцаагчийн хугацаатай албан шаардлага хүргүүлсэн. Мөн Сум дундын ойн ангийн 2019 оны санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж 4518.0 мянган төгрөгийн зөрчил илэрснээс 201.6 мянган төгрөгийн акт тогтоож, 4316.4 мянган төгрөгт зөвлөмж өгч, байгууллагын нягтлан бодогчид Төрийн албаны тухай хуулийн дагуу сахилгын арга хэмжээ тооцуулахаар улсын ахлах байцаагчийн хугацаатай албан шаардлага хүргүүлсэн.

Ус-Ду, Талын илч, Илчлэг шивээ ОНӨААТҮГазруудын 2018-2020 оны санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж, нийт 728206.6 мянган төгрөгийн зөрчил илрүүлж, үүнээс 6019.8 мянган төгрөгийн нөхөн төлбөрийн акт, 4112.3 мянган төгрөгийн хугацаатай албан шаардлага, 304979.0 мянган төгрөгийн зөвлөмжийг хүргүүлсэн.

## **ГУРАВ. ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН БОДЛОГЫН ХҮРЭЭНД**

**Архивын ажлын чиглэлээр:** Архивын баримтыг цахим хэлбэрт шилжүүлэх ажлын хүрээнд 1519 заалт бүхий 8939 хүний нэр, 1884 байгууллагын нэр, 4324 газар зүйн нэр, нийт 5578 хуудас баримтыг цахимжуулсан. Архивын баримтаас 21 иргэнд лавлагаа мэдээлэл олгох үйлчилгээ үзүүлсэн.

**Иргэний бүртгэлийн чиглэлээр:**

- Шинээр гадаад паспорт захиалсан -6
- Иргэний үнэмлэх шинээр олгосон -69
- Төрснөө бүртгүүлсэн хүүхдийн тоо- 30
- Гэрлэлт бүртгүүлсэн тоо - 8
- Гэрлэлт цуцлуулснаа бүртгүүлсэн тоо -1
- Үрчлэлтийн бүртгэлийн тоо - 2
- Нас барсныг бүртгүүлсэн тоо - 5

**Эд хөрөнгийн бүртгэлийн чиглэлээр:**

- Үл хөдлөх хөрөнгийг анхны удаа баталгаажуулах бүртгэл - 3
- Газар өмчлөх эрхийг анхны удаа баталгаажуулах бүртгэл - 21
- Гэрээний бүртгэл - 57
- Барьцааны гэрээний бүртгэл -204
- Эд хөрөнгөд орсон өөрчлөлт, залруулга - 3

**Хуулийн этгээдийн бүртгэлийн чиглэлээр:**

- Шинээр байгуулагдсан хуулийн этгээдийн бүртгэл - 2
- Хуулийн этгээдийн бүртгэлийн өөрчлөлт - 2

**Архивын чиглэлээр:**

- Хуулийн этгээдэд гаргасан лавлагаа, хуулбар - 36
- Иргэнд гаргасан лавлагаа, хуулбар - 144-г олгож, нийт 593 иргэнд төрийн үйлчилгээг хүргэсэн.

**Цагдаагийн хэлтэс нь:** Шуурхай удирдлагын тасагт “Гэмт хэрэг зөрчлийн талаарх гомдол, мэдээллийг хүлээн авах” журамд заасны дагуу 2020 оны эхний хагас жилд иргэд, аж ахуй нэгж байгууллагаас нийт 431 дуудлага, мэдээллийг хүлээн авч, холбогдох арга хэмжээг авч ажилласан.

Гэмт хэргийн шинжтэй гомдол мэдээллийн тоо өмнөх оны мөн үетэй харьцуулахад 52 буюу 41.2 хувиар, зөрчлийн шинжтэй гомдол мэдээлэл 14 буюу 5.8 хувиар, нийт гомдол мэдээлэл 66 буюу 18 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

Хариуцсан нутаг дэвсгэрийн эрүү, хэв журмын нөхцөл байдалд дүн шинжилгээ хийж, гудамж талбай, олон нийтийн газарт гэмт хэрэг, зөрчил үйлдэгдэхээс урьдчилан сэргийлэх, илрүүлэх, таслан зогсоох зорилгоор эргүүл, шалгалтыг тогтмол зохион байгуулж, давхардсан тоогоор 114 алба хаагч 386 цагийн эргүүлийн үүрэг гүйцэтгэж, зөрчил гаргасан 111 иргэнийг эрх бүхий албан тушаалтны зүгээс 36850000 төгрөгөөр торгож, согтуугаар зөрчил гаргасан 42 хүнийг эрүүлжүүлэх, баривчлах, саатуулах байранд хүргэн захиргааны журмаар түр саатуулсан.

“Мотоцикль, хамгаалах малгай, хяналт шалгалт” хэсэгчилсэн арга хэмжээг Авто тээврийн төвтэй хамтран зохион байгуулж, тээврийн хэрэгсэл болон мотоциклийн жолооч 162 иргэнд зам тээврийн осол хэргээс урьдчилан сэргийлэх талаар зөвлөмж хүргүүлэн, яриа таниулга хийсэн. Мөн насанд хүрээгүй хүүхдийг зам тээврийн осол зөрчилд холбогдохоос урьдчилан сэргийлэх сэрэмжлүүлгийг 202 жолоочид хүргэлээ.

“Насанд хүрээгүй хүүхдийг ажиллуулахыг хориглосон ажлын байрны жагсаалт”-ын хүрээнд “Төрийн хяналт шалгалтын тухай”, “Хөдөлмөрийн тухай”, “Хүн худалдаалахтай тэмцэх тухай”, “Хүүхдийн эрхийн тухай”, “Хүүхэд хамгааллын тухай”, “Зөрчлийн тухай хууль”-иуд болон тэдгээрт нийцүүлэн гаргасан хууль эрх зүйн актын хэрэгжилтийг 44 байгууллага аж ахуй нэгжид шалгалаа. Шалгалтаар архи, согтууруулах ундаа худалдан борлуулах тусгай зөвшөөрөлтэй 1 аж ахуйн нэгжид 18 настай хүүхдийг ажиллуулсан, 15 настай хүүхдээр эмнэлгийн барилга дээр тоосго зөөлгөх барилгын туслах ажилтнаар ажиллуулсан зэрэг зөрчлийг илрүүлэн, арилгуулсан.

**Шүүхийн шинжилгээний алба:** Хэргийн газрын үзлэгт 12 удаа ажилласнаас зам тээврийн ослын 3, хулгайлах гэмт хэрэг 2, хүний амь нас эрсэдсэн 2, бусад хэргийн газрын үзлэгт 4 удаа оролцсон. Хэргийн газрын үзлэгийн болон эд мөрийн баримт, эрэн сурвалжлах, танин олуулах ажиллагаа, хэргийн газрын давтан үзлэг, нэгжлэг, цогцос задлан шинжлэх зэрэг ажиллагааны 469 кадр гэрэл зургийг боловсруулан холбогдох материалд хавсаргасан.

**Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар-425 дугаар нээлттэй хорих анги:** Дугуйлангийн үйл ажиллагааг идэвхижүүлэх зорилгоор хүмүүжигчдийн дунд ширээний теннисний тэмцээн зохион байгуулж, 100 хүнийг хамрууллаа.

Аймгийн Боржигин өв музейтэй хамтарч нийт хүмүүжигчдэд цахим музейг үзүүлж, өөрсдийн хийсэн бүтээлүүдийг сурталчлах зорилгоор Монгол Үндэсний олон нийтийн радио телевизээр нэвтрүүлж, музейн урын санд оруулан иргэдэд хүргэж байна.

Цаг үеийн нөхцөл байдалтай холбогдуулан цахим уулзалтын зохион байгуулж, 24 хүний ар гэрт нь цахимаар мэдээлэл хүргэн, 179 удаагийн цахим уулзалт хийсэн байна. Мөн ангийн даргын шийдвэрээр 60-аас дээш настай 8, хөгжлийн бэрхшээлтэй /хэл ярианы бэрхшээлтэй/ -1 хүний цахим уулзалтыг ар гэрийн хүмүүстэй нь холбоо тогтоон зохион байгуулсан.

2020 оны 6 дугаар сарын 11-ний өдрийн байдлаар 964425611 төгрөгийн гэм хорын төлбөртэй 44 хүмүүжигч байгаагаас 13 хүний 51345971 төгрөгийн хохирлыг төлүүлсэн байна.

Улсын бүртгэлийн хэлтэстэй хамтран 10 хүнийг бичиг баримтжуулсан.

2020 оны 6 дугаар сард төлбөрийн 90 гүйцэтгэх баримт бичгээс 47 гүйцэтгэх баримт бичгийн 86523466 мянган төгрөг, 9 хүүхдийн тэтгэлгийн баримт бичгийг бодитой биелүүлж гүйцэтгэх хуудасны бодит биелэлт 46.2 хувьтай байна.

**Мэргэжлийн хяналтын газар нь:** Мэргэжлийн хяналтын ерөнхий газраас ирүүлсэн үүрэг чиглэлийн дагуу Монгол улсын Их хурлын сонгуулийн нам, эвслийн нээлтийн үйл ажиллагааны үед Засгийн газрын 188 дугаар тогтоолоор баталсан журмын хэрэгжилтэд хяналт тавьж, зөвлөгөө зөвлөмжөөр хангаж ажиллав. Сонгуулийн хэсгийн хороод болон УИХ-ын сонгуульд бие даан нэр дэвшигч, нам эвслүүдийн сонгуулийн штабуудад коронавирусын халдвараас сэргийлж ажиллах, Засгийн газрын 188 дугаар тогтоолыг хэрэгжүүлж ажиллах талаар зөвлөмж хүргүүлж гүйцэтгэлд нь хяналт тавьж ажилласан. Эрүүл мэндийн хувьд сэжигтэй тохиолдол илрээгүй.

Тайлант хугацаанд төлөвлөгөөт 10, төлөвлөгөөт бус 2 шалгалтыг зохион байгуулж, 1 аж ахуйн нэгжид зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэн, улсын байцаагчийн 8 зөвлөмж, дүгнэлт, 38 албан шаардлага, 5 акт, 12 удирдамж боловсруулан, холбогдох аж ахуйн нэгжүүдэд хүргүүлж, хэрэгжилтийг хангуулан ажиллаж байна.

Мөн эмийн сангуудад хийсэн төлөвлөгөөт шалгалтаар хэрэглэх хүчинтэй хугацаа дууссан тарилгын шингэнээр үйлчилж байсан зөрчил илэрч хялбаршуулсан журмаар 1000000 төгрөгийн шийтгэвэр ногдуулан, 6 нэр төрлийн 23 ширхэг тарилгын шингэнийг хурааж авсан.

Мэргэжлийн хяналтын газрын дэргэдэх чанарын лабораторт усны 25, хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний 36, хоолны 10, ариутгалын бодисны 1, арчдасны 101, нийт 173 сорьцонд 2-8 үзүүлэлтээр хими, нян судлалын шинжилгээг гүйцэтгэсэн бөгөөд 37 сорьц эерэг дүн үзүүлсэнийг тодорхойлсон.

#### **Онцгой байдлын газар нь:**

Шивээговь сумын гамшгийн эрсдэлийн түвшинг тодорхойлж, эрсдэлийн ерөнхий үнэлгээг хийлээ. Ерөнхий үнэлгээгээр тус сумын эрсдэлийн түвшин ДУНД үнэлэгдсэн.

Явуулын болон хөдөлгөөнт шатахуун түгээх автоцистерний жолооч нарт “Явуулын ШТС-д тавигдах шаардлага” сэдвээр сургалт зохион байгуулж, шатахуун хадгалах савны хана хоорондын зайн битүүмжил, амьсгалын хавлага, орлого, зарлагын хоолой, цахилгааны тэжээл, аккумуляторын зай хэмжээ, гал унтраах анхан шатны багаж хэрэгсэл, сав, шатахуун түгээх станцын тусгай зөвшөөрөлийг шалган аюулгүй байдлыг хангуулсан.

“Галын аюулгүй байдлын дүгнэлт гаргах журам”-ыг мөрдлөг болгон иргэнээс ирүүлсэн 3, ААНБ-аас 13, нийт 16 хүсэлтийн дагуу хяналт шалгалтыг зохион байгуулан, мэргэжил, арга зүйн зөвлөмж өгч, ажлын байрны галын аюулгүй байдлын дүгнэлтийг олгож, нийт 350000 төгрөг, 2 барилгын ажлын зургийг хянаж тэмдэгтийн хураамж 450000 төгрөгийг тус тус орон нутгийн орлогт төвлөрүүлсэн.

2020 оны 6 дугаар сард аймгийн хэмжээнд гал түймрийн 4 удаагийн дуудлага бүртгэгдэж, 4 удаагийн гал түймрийг унтраах арга хэмжээг авч хэрэгжүүлсэн бөгөөд иргэн, аж ахуй нэгжид 10.0 сая төгрөгийн хохирол учирсныг тогтоон, 18.0 сая төгрөгийн эд хөрөнгийг авран хамгаалсан байна.

### **ДӨРӨВ. БОЛОВСРОЛ, СОЁЛ, ЭРҮҮЛ МЭНД, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН БОДЛОГЫН ХҮРЭЭНД**

**Боловсролын чиглэлээр:** Боловсролыг дэмжих аймгийн дэд хөтөлбөрийн хүрээнд “Чанарын үнэлгээ”-нд хамрагдах 4,9,11 дүгээр ангийн сурагчдын дунд 5 хичээлээр цахим сорилго шалгалт зохион байгуулж, нийт 950 сурагч хамрагдсан.

Элсэлтийн Ерөнхий шалгалтад бэлтгэх давтлагын явц, үр дүнгийн талаар сурагчдаас судалгаа авч, нийт 132 хүүхэд хамрагдсан.

2025 оноос төрийн албан бичиг хөтлөлт, хос бичигт шилжихтэй холбогдуулан хүүхэд багачууд, иргэд, ААН, албан байгууллагуудад үндэсний бичгийг түгээн дэлгэрүүлэх “Сайхан бичигтэн-2020” үндэсний бичгийн цахим уралдааныг зохион байгууллаа.

Уралдаанд байгууллагын төрөлд 11 байгууллага, иргэн төрөлд 266 иргэн, Ахлах ангийн төрөлд 39 сурагч, Дунд ангийн төрөлд 75 сурагч, нийт 380 иргэд, сурагчид оролцлоо.

**Гэр бүл, хүүхэд, залуучуудын чиглэлээр:** Олон улсын гэр бүлийн өдрийг угтан “Миний гэр бүлийн аз жаргал” аяныг 2020 оны 5 сарын 1-ний өдрөөс 6 сарын 1-ний өдрийн хооронд зохион байгуулж, “Миний гэр бүлийн өглөөний дасгал”, “Үлгэрч аав, ээж”, “Гэр бүлээрээ Тик Ток хийцгээе”, “Угийн бичиг хөтөлдөг шилдэг гэр бүл”-ээр 7 гэр бүлийг шалгаруулан, шагнаж урамшуулсан.

**Соёл, урлагийн чиглэлээр:** Аймгийн Боржигин өв музейгээс 2020 оны 5 дугаар сарын 20-оос 6-р сарын 20-ны өдрийн хугацаанд танхимаар 24, музейн “VRBOX” үйлчилгээг 6 байгууллагын 198 хүнд хүргэн үйлчилж, соёлын өвийг сурталчилсан.

6 дугаар сарын 11-13-ны өдрүүдэд Соёлын өвийн үндэсний төвтэй хамтран Мөнхийн овоо, Сансар зуслан, Даллагын хад, Өвөрдэлгэр, Ардэлгэр, Малх толгой, Зараа булан, Зараа толгой, Зараагийн хүн чулуу, Зараа булгийн хөшөөт булш, Төмөр утасны хороо, Шивээговь сумын нутаг Баянхошууны говь зэрэг 13 дурсгалт газрын 139 дурсгалын байршлыг тогтоож бүртгэлжүүлсэн.

Хөдөөгийн 4,5 дугаар багийн иргэдэд нүүдлийн номын сангаар үйлчилж, 35 өрхийн 50 иргэнд шинээр карт нээж, 244 иргэнд гарын авлага тараасан.

Боржигин чуулгын уран бүтээлчид 6 дугаар сарын 1-ний өдөр Хүүхдийн эрхийг хамгаалах өдөрт зориулан “Мөрөөдлийн ертөнцөөр” тоглолтыг цахимаар дамжуулан хүүхэд багачуудад хүргэснийг 2600 гаруй хүүхэд багачууд, иргэд үзсэн байна.

**Биеийн тамир, спортын чиглэлээр:** Аймгийн төвд “Өглөөний гүйлт, дасгал”-ыг тогтмолжуулж, давхардсан тоогоор 240 гаруй иргэн хамрагдсан байна.

Мөн гүйлт, дасгалд идэвхитэй оролцохыг уриалж, тус арга хэмжээнд тасралтгүй оролцож байгаа иргэдэд 1.0 сая төгрөгийн спортын хэрэглэл, витамин, маск зэргийг олгосон.

**Эрүүл мэндийн чиглэлээр:**

Үзүүлэлт	2019 оны 06 сар	2020 оны 06 сарын 20-ны байдлаар
Төрсөн эх	209	212
Гэрийн төрөлт	1	0
Амьд төрсөн хүүхэд	210	214
Амьгүй төрөлт	2	0
Нас баралт	26	32
Эмнэлгийн нас баралт	7	2
Хоног болоогүй нас баралт	3	0
0-1 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл	4	0
1-5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл	0	2
Эмнэлгээс гарсан хүний тоо	2514	2068
Амбулаторийн үзлэг	48976	43574
Халдварт өвчин	104	53

Аймгийн Нэгдсэн эмнэлэг, өрхийн эрүүл мэндийн төвийн эмч, мэргэжилтнүүд 24 цагаар үүрэг гүйцэтгэн Дорноговь аймгийн Замын-Үүд сумаас Сүмбэр суман дахь цагдаагийн хяналтын цэгээр дайран өнгөрөх автомашинаар зорчигч нийт 3032, хот хоорондын зорчигч тээврийн хэрэгсэл автобусаар зорчигч 3170 хүний биеийн байдалд хяналт тавьж ажилласан.

Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын суурин төлөөлөгч Сергей Диордица болон холбогдох албаны хүмүүс орон нутагт 6 дугаар сарын 18, 19-ний өдрүүдэд ажиллаж, Коронавируст (COVID 19) халдварын үеийн эмнэлгийн бэлэн байдлыг хангах дадлага сургуулилтыг зохион байгууллаа.

Сүмбэр сумын хөдөөгийн 5, 6 дугаар багийн нийт 112 өрхийн 185 иргэнийг эрт илрүүлэг, үзлэг шинжилгээнд хамруулж, алсын зайн оношлогооны ЭХО, зүрхний цахилгаан бичлэг, элэгний В,С вирус, БЗДХ/ ДОХ, тэмбүү, хөхний хорт хавдар илрүүлэх, артерийн даралт, чихрийн шижин илрүүлэг үзлэг хийгдсэн.

Аймгийн Нэгдсэн эмнэлгийн 100 ортой шинэ барилга ашиглалтанд орохтой холбогдуулан аймгийн Орон нутгийн хөгжлийн сангийн 40.0 сая төгрөгөөр 10 нэр төрлийн 160 ширхэг тоног төхөөрөмжийг худалдан авч, хүлээлгэн өгсөн.

**Хөдөлмөр эрхлэлтийн чиглэлээр:** Ажлын байрыг дэмжих хөтөлбөрийн хүрээнд "Бүлгийн зохион байгуулалттай хүнсний ногоо тариалах" арга хэмжээнд ажилгүй 18 иргэнийг хамруулахаар Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газраас гэрээ байгуулан, Хүнс, хөдөө аж ахуйн газраас олгосон усалгаатай 3 га задгай талбайд төмс, хүнсний ногоо, 410м<sup>2</sup> талбайтай 5 хүлэмжид тариалалт хийж байна. Хүнсний ногоо тариалахтай холбоотой үр, бордоо, багаж хэрэгсэл, тоног төхөөрөмж худалдан авах, хашаа хайс хүлэмж барих, амралтын гэр байр барих, хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангах болон бусад үйл ажиллагааны 6802.7 мянган төгрөгийн зардлыг Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас олгосон.

Өрхийн үйлдвэрлэл эрхэлж, ажлын байр бий болгох хүсэлтэй 12 ахмадаас 35000,0 мян.төгрөгийн санхүүгийн дэмжлэг хүссэн төсөл хүлээн авч, төслийг сонгон шалгаруулж, 8 ахмадад 15000,0 мян төгрөгийн дэмжлэг үзүүлсэн.

2020 оны 6 дугаар сарын байдлаар 3 удаа Амьжиргааг дэмжих зөвлөлийн хурлыг зохион байгуулж, амьжиргааг дэмжих мөнгөн тэтгэмж болон асаргааны мөнгөн тэтгэмжийг гэмнэлэгийн хяналтанд байнгын асаргаанд байдаг 4 ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэн, хүүхдэд шинээр, 5 иргэнд үргэлжлүүлэн, бүтэн өнчин хүүхдийн асаргааны тэтгэмжийг 2 иргэнд шинээр, тэжээгч нь нас барсан 0-18 настай хүүхдийн тэтгэвэрийг 1 иргэнд, өрх толгойлсон эхийн тэтгэмжийг 1 иргэнд тус тус олгохоор шийдвэрлэсэн.

Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээг гүйцэтгэх аж ахуй нэгж байгууллагыг сонгон шалгаруулж, "Өөрчлөлтийн хөтөч, донтолтоос сэргийлэх сургалт зөвлөгөөний институт" ТББ, Өдрийн үйлчилгээний чиглэлээр "Монголын хараагүйчүүдийн үндэсний холбоо" ТББ, сургалтын чиглэлээр "Ирмүүн төгс" ТББ, сэргээн засах үйлчилгээний чиглэлээр "Гэгээн мандарваа" ХХК уламжлалт анагаах ухааны эмнэлэг, "Говийн сондор" ХХК-ийн "Энхбилэг" сэргээн засах эмнэлэгүүдтэй гэрээ байгуулан ажиллаж байна.

## **ТАВ. ХӨДӨӨ АЖ АХУЙН БОДЛОГЫН ХҮРЭЭНД**

**Мал, аж ахуйн чиглэлээр:** Аймгийн Засаг даргын 2020 оны А/127 дугаар захирамжийн дагуу мал сүрэгт үзлэг ангилалт хийх, цөм сүрэг бүрдүүлэх, ялган тэмдэглэж, бүртгэлжүүлэх ажил хийгдэж байна. Цөм сүрэг бүрдүүлэхээр Сүмбэр сум Сүмбэр үүлдрийн 900 толгой хонийг, Шивээговь сум нутгийн Монгол үүлдрийн 5000 толгой хонийг, Баянтал сум нутгийн Монгол үүлдрийн 800 толгой адууг бүртгэлжүүлсэн. Мөн Сүмбэр үүлдрийн 800 хонинд хувьсын ангилалт хийгээд байна.

Малын бүртгэл мэдээллийн цахим санд 2010-2015 оны хооронд бүртгэлжүүлсэн малыг хасах, шинээр ээмэглэсэн малыг бүртгэлжүүлэх ажил хийгдэж, 2020 оны 6 дугаар сарын 15-ны байдлаар 619 малыг хасч, 503 малыг шинээр бүртгэлжүүлээ.

Бог малын хээлтүүлэгчийг ялган төвлөрүүлэх ажлын хүрээнд ялгавал зохих 2730 богийн хээлтүүлэгчээс 1629-ийг ялгаж, хэрэгжилт 59.2 хувьтай байна.

2020 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн байдлаар төллөвөл зохих 183675 эх малаас 166441 нь төллөж, 166798 төл гарсанаас бойжиж байгаа төл 159766 байна. Мал төллөлт 90.6, төл бойжилт 95.8 хувьтай байгаа бөгөөд төлийн хорогдол 7032, том малын хорогдол 4383 байна.

2019 онд бэлтгэж, үндэсний үйлдвэрт тушаасан 331 өрхийн 55852 ш арьс, ширэнд 163.4 сая төгрөг, 214 өрхийн 78.3 тн хонь, тэмээний ноосонд 110.1 сая төгрөгийн урамшууллыг олголоо.

2020 оны 6 сарын 17-ны өдрийн байдлаар нийт 16.105 га талбайд төмс, 12.24 га талбайд хүнсний ногоо, 1 га-д тэжээлийн ургамал, 0.56 га жимс, жимсгэнэ тариалсан. Цаг агаарын нөхцлөөс шалтгаалан тариалалтын ажил удаашралтай явагдаж байна. Хүнсний нарийн ногооны үрсэлгээг 3 иргэн, модны суулгацыг 1 иргэн бэлтгэн, орон нутгийн иргэдэд нийлүүлж байна. Тариалалтын ажлыг 13 иргэн, 1 аж ахуйн нэгж эхлүүлсэн бөгөөд тус ажилд 2 зүтгэх хүчний трактор, чиргүүл, дүүжин машин, 2 бага оврын трактор, иж бүрдлийг ашиглаж, техникийн үйлчилгээг 2 цэгээс үзүүлэн, 2020 оны 5 дугаар сарын 20-ны өдрийн байдлаар 5.2 га талбайд хөрс боловсруулалтын ажил хийгдсэн.

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамнаас өрхийн тариалан эрхлэгчдийг дэмжих зориулалтаар 9 төрлийн 52 кг хүнсний ногооны үрийг хуваарилсанаас, 36 иргэнд 15 кг үр олгосон.

Төмс, хүнсний ногоо, жимс, жимсгэнэ тариалах хүсэлтэй 21 иргэнийг арга зүйн зөвлөмжөөр ханган, шинээр ногоо тариалах санаачилга гаргасан 2 иргэнийг Шивээгийн булгийн услалтын систем түшиглэн тариалалт хийлгүүлэхээр шийдвэрлэсэн.

Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох ажлын хүрээнд холбогдох журам, зээл олгох мэдээлэл, зарыг орон нутгийн телевиз, байгууллагын цахим хуудсаар мэдээлж, 200 гаруй гарын авлага тараасан. Мөн 4 дүгээр сарын 16-ны өдрөөс 5 дугаар сарын 19-ний өдрийг дуустал хугацаанд аж ахуйн нэгжүүдийн төсөл хүлээн авах ажлыг зохион байгуулж, нийт 3.3 тэрбум төгрөгийн 21 төсөл хүлээн авч, журмын дагуу төслүүдийг программд бүртгэн, иж бүрдлийн болон эхний шатны шалгаруулалтыг хийж байна.

**Аймгийн төвийн захууд, томоохон худалдааны төвүүдийн хүнсний бараа  
бүтээгдэхүүний үнийг өнгөрсөн сарын үнэтэй харьцуулан гаргасан  
2020 оны 6 дугаар сарын үнийн мэдээ**

Зах зээлд худалдаалагдаж буй Үхрийн /ястай/ махны үнэ 500 төгрөгөөр, хонины мах /цул/ 500 төгрөгөөр, адууны мах /цул/ 500 төгрөгөөр, ямааны мах /цул/ 500 төгрөгөөр, төмс 250 төгрөгөөр зарим хүнсний ногооны үнэ өнгөрсөн сараас 50-250 төгрөгөөр нэмэгдсэн үзүүлэлттэй байна. Бусад бараа бүтээгдэхүүний үнэ тогтвортой байна.

№	Бараа бүтээгдэхүүн	Дээд үнэ төг	Доод үнэ төг	Өссөн буурсан	
1	Үхрийн мах	Ястай	10000	8500	+500
		Цул	12000	11000	-
2	Хонины мах	Ястай	8000	7000	
		Цул	10000	10000	+500
3	Адууны мах	Ястай	8500	7500	
		Цул	9000	9000	+500
4	Ямааны мах	Ястай	7000	6000	
		цул	9000	9000	+500
5	Тахианы мах	Гуя	10500	10000	
		мөч	9800	9000	
6	Лууван	монгол	2000	1200	-
		хятад			
7	Төмс	монгол	1250	850	+250
		хятад			
8	Байцаа	монгол	1500	1200	

		хятад			-
9	Чинжүү	МОНГОЛ			-
		хятад	6500	5500	
10	Манжин	монгол	3800	3200	+50
		хятад			-
11	Сонгино бөөрөнхий	Монгол	3000	2500	-
		Хятад	1500	1400	-
12	Улаан лооль	монгол	6000	5500	-
13	Өргөст хэмх	монгол	8000	6500	-
14	Элсэн чихэр	монгол	2100	1600	-
15	Будаа	Цагаан задгай кг	2500	2200	+100
		Шар слава кг	3500	3000	-
		Гурвалжин будаа кг	3800	2200	-
16	Сүү	Задгай	2500	2000	-
		Сүү ХХК 0,5л			
		Сүү ХХК 1л	3200	3050	-
17	Тараг	Задгай	2200	2000	-
		Сүү ХХК 1л цөцгийтэй тараг	4800	3800	-
18	Талх	Чойр талх	1200	750	-
19	Өндөг	ОХУ	400	330	-
		Монгол	400	300	-
20	Алтан тарианы гурил	Задгай дээд	1520	1480	+250
		Задгай 1-р зэрэг	1140	1100	+20
		Задгай 2-р зэрэг	1000	950	-
		Савласан д/дээд /	2400	2300	-
		Савласан дээд	2200	2100	-
		Савласан 1-р зэрэг	1400	1300	-
		Савласан 2-р зэрэг	1500	1450	-
21	Ургамлын тос	Олейна	5500	4800	+50
		Алтан	3800	3600	-
22	Гоймон	Алейка	1800	1600	-
		А/тариа савхан	1100	950	-

### **ЗУРГАА. БАЙГАЛЬ ОРЧИН, ҮЙЛДВЭР, ҮЙЛЧИЛГЭЭ, ДЭД БҮТЦИЙН САЛБАРЫН БОДЛОГЫН ХҮРЭЭНД**

**Байгаль орчны чиглэлээр:** “Нийтийн эзэмшлийн гудамж, талбайн ногоон байгууламжийн усалгааны шугам хоолой, ус нөөцлөх сав суурилуулах” ажлыг БХНСАХЗ-ын 29.7 сая төгрөгөөр “Жавхлант Арвижих” ХХК гүйцэтгэж хүлээлгэн өгсөн.

“Цэргийн алдар” цогцолборын цэцэрлэгт ногоон байгууламжид ус нөөцлөх сав, усалгааны шугам хоолой суурилуулах ажил 40 хувьтай хийгдэж байна.

Сүмбэр сумын 1 дүгээр багт шинээр байгуулагдсан “Ногоон төгөл-Ногоон паспорт” модлог ургамлын цэцэрлэгийн ногоон байгууламж, тохижилтын ажлыг “Батбадрах Дэлгэр” ХХК гүйцэтгэж, 1150 ширхэг мод, бут тарьж, ургуулж байна.



Сум дундын ойн анги улсын төсвийн санхүүжилтээр Сүмбэр сумын 4 дүгээр багийн нутагт Улсын чанартай авто замын дагуу 5 га талбайд 3312 ширхэг мод бут тарьсан.

Байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлаар “Ойн биологийн олон янз байдлын төв” НҮТББ “Аймгийн хэмжээнд цөлжилтийн судалгаа”-г хийж байна.

Байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний 2.0 сая төгрөгөөр Умард говийн гүвээт, халхын дундад талын усны сав газрын захиргаатай гэрээ байгуулан аймгийн хэмжээнд усны нэгдсэн тоо бүртгэлийн ажлыг гүйцэтгүүлж, 433 худаг, 20 булаг, 6 гол, 8 нуур, тойром, 1 баянбүрд, 1 рашаан, 3 хөв цөөрөм, 7 газрын доорх усны орд, нийт 479 уст цэгийг тоолж бүртгэсэн.

Баянтал сумын Засаг даргын Тамгын газраас ирүүлсэн хүсэлтийн дагуу 2020 оны 5 дугаар сарын 28-ны өдөр Мэргэжлийн хяналтын газар, Прокурорын газар, Цагдаагийн хэлтэс, Ус цаг уур, орчны шинжилгээний төв, Умард говийн гүвээт, халхын дундад талын усны сав газрын захиргаатай хамтран зөвшөөрөлгүй ус ашиглаж буй “Бигом Чойр” ХХК-ийн үйл ажиллагаанд хамтарсан хяналт шалгалт хийж үйлдвэрлэлд ашиглаж байсан 2 худгийг лацдан битүүмжилсэн. Мөн үйлдвэрийн орчны агаар, хөрс, уснаас дээж авч Байгаль орчин, хэмжил зүйн төв лабораторид шинжилгээнд хамруулахаар хүргүүлээд байна.

Умард говийн гүвээт, халхын дундад талын усны сав газрын захиргаанаас гаргасан дүгнэлтийг үндэслэн 30 иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад хаягдал ус хаях, зайлуулах зөршөөрлийг олгосон.

2019 онд байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилт ирүүлээгүй 1 аж ахуйн нэгжид Мэргэжлийн хяналтын улсын байцаагчийн шийдвэрээр 500000 төгрөгийн торгууль ногдуулж, 2020 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг Байгаль орчин, аялал, жуулчлалын яамаар батлуулахаар хүргүүлээд байна.

Ус, цаг уур, орчны шинжилгээний төвөөс цахим хаяг болон орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр 6 дугаар сард 8 хугацааны мэдээг нийт 240, Хөдөө аж ахуйн тойм, 10 хоногийн тойм мэдээг нийт 3 удаа, сарын тойм мэдээг 1 удаа тус тус дамжуулсан.

Энэ сард агаар бохирдуулагч элементүүд болох азотын давхар исэл ( $\text{NO}_2$ ), хүхэрлэг хийн давхар ислийг ( $\text{SO}_2$ ) хоногт 3 удаа нийт 30 сорьцыг авч, 6 дугаар сарын 1-17-ны өдрүүдийн дээжинд шинжилгээ хийхэд, азотын давхар исэл ( $\text{NO}_2$ ) дунджаар 0.020мкг/мг, хүхэрлэг хийн давхар исэл ( $\text{SO}_2$ ) 0.014мкг/мг байгаа нь хүлцэх агууламжаас хэтрээгүй байна.

**Газрын харилцаа, барилга, хот байгуулалт, хөрөнгө оруулалтын талаар:** Сумдын 2020 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөгөөр батлагдсан гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар өмчлүүлэх газар нь Засгийн газрын 2020 оны “Иргэнд 2020 онд өмчлүүлэх газрын нийт хэмжээ, байршил, зориулалтыг тогтоох тухай” 170 дугаар тогтоолоор батлагдаагүй тул мэдээллийг иргэдэд цахимаар хүргэж байна.

7 иргэнд Шивээговь сум, Дорноговь аймгийн Даланжаргалан сумын нутагт дэвсгэрийн хилийг дамнуулан өмчлөлийн зориулалттай олгосон байсныг зөрчлийг арилгуулан, сумын Засаг даргын 2020 оны А/90 дугаар захирамжаар өмнөх шийдвэрт өөрчлөлт оруулан шийдвэрлэсэн.

Газрын кадастрын мэдээллийн сангийн нөхөн бүрдүүлэлтийн хүрээнд Шивээговь сумын Чойр гудамжны өмчлөлийн 12 иргэний нөхөн бүрдүүлэлтийг хийсэн.

“Үндэсний хэмжээний газар ашиглалт, газар ашиглалтын өөрчлөлтийн үнэлгээ” хийх ажлын хүрээнд аймгийн хэмжээнд үнэлгээ хийх 5203 цэгээс 254 цэг дээр үнэлгээ хийгээд байна.

Шивээговь суманд 6 дугаар сарын 12-ны өдөр газрын цахим биржийн [www.mle.mn](http://www.mle.mn) хаягаар 1-р багт Уурхайчдын гудамж буюу 3 дугаар сургуулийн урд талд 900 м<sup>2</sup> талбай бүхий газарт дуудлага худалгааг зохион байгуулсан.

Мөн Сүмбэр сумын Засаг даргын 2020 оны 5 дугаар сарын 27-ны өдрийн А/100 дугаар захирамжаар Сүмбэр сумын 1 дүгээр багт Чойр ложистик ХХК-ийн зүүн талд 10 га /100000м<sup>2</sup>/

газрыг үйлдвэрлэлийн зориулалтаар олгохоор дуудлага худалдааны зарыг газрын цахим биржийн [www.mle.mn](http://www.mle.mn) сайтанд байршуулсан.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2019-2020 онд дамжин хэрэгжиж байгаа 100 ортой Нэгдсэн эмнэлгийн барилгын ажил 70 хувьтай, Сүмбэр сумын 640 хүүхдийн суудалтай сургуулийн барилга угсралтын ажил 55 хувьтай, Сүмбэр сумын 150 хүүхдийн суудалтай цэцэрлэгийн барилга угсралтын ажил 45 хувьтай, Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих төвийн барилга угсралтын ажил 35 хувьтай, Сүмбэр сумын 2 дугаар багийн гэр хорооллыг цэвэр усны шугамд холбох, Тэрэгтийн эх үүсвэрт өргөх станц, цэвэршүүлэх тоног төхөөрөмж тавих ажил 60 хувьтай, Чойрын хийдийн гол дуганы барилга 65 хувьтай тус тус хийгдэж байна. Мөн Сүмбэр сумын 2 дугаар цэцэрлэгийн барилгын их засвар, Усан спорт сургалтын төвийн барилга угсралтын ажлууд дуусч, улсын комисс ашиглалтад хүлээн авсан.

Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр баригдаж байгаа Сүмбэр сумын 150 хүүхдийн суудалтай цэцэрлэгийн барилга угсралтын ажил 60 хувьтай, Япон улсын Засгийн газрын ЖАЙКА ОУБ-ын “Өвсний үндэс” хөтөлбөрийн хөрөнгөөр хийгдэж байгаа Сүмбэр сумын 1 дүгээр цэцэрлэгийн их засварын ажил 50 хувьтай байна.

АОНХСангийн хөрөнгөөр хийгдэж байгаа Сүмбэр сумын 6 дугаар байрны фасад засварын ажил 90 хувьтай, Найрамдал хотхоны өргөх станцын барилгын ажил 55 хувьтай, Сүмбэр сумын 2, 3 дугаар багт тоглоомын талбай байгуулах ажил 20 хувьтай байгаа бол Найрамдал хотхоны байрнуудын дээвэр засварын ажил дуусч, улсын комисс хүлээн авсан.

#### **Худалдан авах ажиллагааны талаар:**

Улсын төсвийн хөрөнгөөр 9 ажил хийгдэхээр төлөвлөснөөс 2020 оны 6 дугаар сарын 22-ны өдрийн байдлаар 7 ажлын тендер шалгаруулалтыг зарлаж, 6 ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж, гэрээ байгуулсан бөгөөд 1 ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийг үнэлэх шатанд байгаа бол 2 ажлыг тендер зарлагдаагүй байна.

Орон нутгийн хөгжлийн сан, Орон нутгийн хөрөнгө оруулалтаар нийт 16 ажил хийхээр төлөвлөснөөс 2020 оны 6 дугаар сарын 25-ны өдрийн байдлаар 14 ажлын тендер шалгаруулалтыг зарлаж, 12 ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж гэрээ байгуулсан бөгөөд 1 ажлын тендерийг үнэлэх шатанд байна. 1 бараа худалдан авах ажиллагаа гэрээ байгуулах шатанд байгаа бол 2 ажлыг зарлаагүй байна.

Авто замын сан, Байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлаар хийгдэхээр 5 ажил төлөвлөснөөс 6 дугаар сарын 25-ний өдрийн байдлаар 5 ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулан, гэрээ байгуулж, ажлыг гүйцэтгүүлж байна.

### **ДОЛОО. СУМ ОРОН НУТГИЙН ТАЛААР**

**Баянтал сум:** Цэцэрлэг, сургуулийн үйл ажиллагаа зогссонтой холбоотойгоор цэцэрлэгийн 30 хүүхдэд нийт 913200 төгрөгийн үнэ бүхий хичээлийн болон ариун цэврийн хэрэгслийг буцаан олгосон.

Сумын нутаг дэвсгэрт үер буусантай холбоотойгоор үүссэн мал, амьтны сэг зэмийг устгах, ариутгал халдваргүйтгэл хийх ажлыг зохион байгууллаа. Тус ажлын хүрээнд Засаг даргын нөөц хөрөнгөөс 889620 төгрөг зарцуулан, Сүүл толгой, Гашууны голд үүссэн сэг зэм, зүй бусаар хорогдсон 1015 толгой малын сэг зэмийг тус тус устгаж, 334.4 м2 талбайд халдваргүйтгэл хийлээ.

**Шивээговь сум:** Сумын Засаг даргын 2020 оны 5 дугаар сарын 20-ны өдрийн А/87 дугаар захирамжаар “Хагас жилийн малын түүвэр судалгаа зохион байгуулах” комисс томилон, 5 дугаар сарын 25-29-ний өдрүүдийн хооронд тооллогын ажлыг зохион байгуулж, түүврээр сонгогдсон 36 өрхийн 25139 толгой малыг тооллогод бүрэн хамруулсан.

Ажлын байрыг дэмжих хөтөлбөрийн хүрээнд нийтийг хамарсан ажлыг 2020 оны 6-р сарын 08-ны өдрөөс эхлэн 10 хоногийн хугацаанд зохион байгуулан зорилтод бүлгийн 3 иргэнийг түр ажлын байраар хангаж сумын нийтийн эзэмшлийн гудамж талбайн модыг

тогоолох, услах, зүлэг болон цэцэгийн үр суулгах ажлуудыг хийж гүйцэтгүүлэн нийт 735000 төгрөгийн цалинг олгоод байна. Мөн Сумын зорилтот бүлгийн 17 иргэнтэй хамтран сумын төвийн цэцэрлэгт хүрээлэн, зам дагуух ногоон байгууламжийн зурвасын хог хаягдлыг цэвэрлэсэн.

Сумын Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2021 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл арга хэмжээний саналыг сумын 725 өрхөөс цаасаар, 83 өрхөөс цахимаар авч, нийт өрхийн 76 хувиас саналыг авч, 1, 2 дугаар багийн ИНХ-ын Тэргүүлэгчдийн хурлыг зохион байгуулж, багийн ИНХ-ын тогтоолоор баталсан.

Сумын 2020 оны Орон нутгийн хөгжил сангийн 34.0 сая төгрөгөөр “Сумын төвөөс засмал зам хүртэл хатуу хучилттай засмал зам тавих ажлын зураг төсөв боловсруулах” ажлыг “Арвай нутгийн зам” ХХК-аар гүйцэтгүүлж байна.

Сумын Орон нутгийн хөгжлийн сангийн 4.9 сая төгрөгөөр Эрхэм Мөнх ХХК-тай гэрээ байгуулан “Эрүүл мэндийн төвд хэвтэн эмчлүүлэгчийн ор худалдан авах” ажлыг гүйцэтгүүлж байна.

Сумын төв талбайн тохижилтын ажлыг Оч хийц ХХК-аар гүйцэтгүүлж, Улсын комисст хүлээлгэн өгөхөд бэлэн болоод байна.

Сумын Хүүхэд залуучуудын хөгжлийн дэд хөтөлбөрийн 1.2 сая төгрөгөөр “Хүүхдийн номын фондыг нэмэгдүүлэх ажил”-ыг зохион байгуулж, 45 нэр төрлийн 109 ширхэг номыг сумын Соёлын төвд хүлээлгэн өгсөн.

**Сүмбэр сум:** Сүмбэр сумын Засаг даргын А/60 дугаар захирамжийн дагуу сумын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж байгууллагуудын орчны болон нийтийн эзэмшлийн гудамж талбайн цэвэрлэгээг зохион байгуулж, 10 байгууллагын албан хаагчид 1.7 га газрыг цэвэрлэж, 3 тонн хог хаягдлыг төвлөрсөн хогийн цэгт төвлөрүүлсэн.

Усны ай сав газраас хаягдал усны дүгнэлт гарч ирсэний дагуу дүгнэлтийг үндэслэн төвлөрсөн системд холбогдсон 27 байгууллагад хаягдал ус хаях, зайлуулах зөвшөөрлийн бичиг олгож, төвлөрсөн системд холбогдоогүй 3 байгууллагатай ус бохирдуулсны төлбөрийн гэрээ байгуулж, зөвшөөрлийн бичиг олгон ажиллалаа.